



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №35

2019 оны 10-р сарын 28-наас 11-р сарын 01

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт **982** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 114(11.6%) галзуугийн эрсдэлд өртсөн, 836(85.1%) хачигт халдвар, 8(0.8%) боом, 7(0.7%) тарваган тахал, 3(0.3%) хумхаа, 1(0.1%) ям, 5(0.5%) денги, 5(0.5%) бэтэг, 3(0.3%) бруцеллез өвчний сэжигтэй тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

1.1 Боомын хүний өвчний сэжигтэй тохиолдол

Дорнод аймгийн Баян-Уул сумаас боомын хүний өвчний сэжигтэй 1 тохиолдол бүртгэгдэж, тархвар судлал, эмнэлзүйн шинж тэмдэг, лабораторийн шинжилгээгээр онош үгүйсгэгдсэн байна. Тус суманд боомын голомт тэмдэглэгдээгүй, сүүлийн 30 жил хүний өвчлөл гарч байгаагүй байна.

1.2 Мэрэгч амьтны дуудлага

Энэ долоо хоногт нийслэлийн СХД, ЧД, ХУД-ээс ирүүлсэн мэрэгч амьтны 6 удаагийн дуудлаганд үйлчилж, сорьцод лабораторийн шинжилгээ хийж байна. Он гарсаар 5 дүүргийн хэмжээнд нийт 91 удаагийн амьтны дуудлаганд үйлчилж, хураагдсан сорьц материалыг ЗӨСҮТ-ийн лабораторид шинжлэхэд тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчин үүсгэгч илрээгүй байна.

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Монгол улсад:

Мал, амьтны галзуугийн өвчлөл:


Өвөрхангай аймгийн Төгрөг сумын Мазар багийн “Дэл” гэдэг газар малчин “Х”-ийн 1 үхэр 2019 оны 10 дугаар сарын 27-ны өдөр галзуу өвчний шинж тэмдэгтэй хорогдсон тул дээж авч аймгийн МЭАЦЛ-д шинжлүүлэхэд галзуу өвчин болох нь тогтоогдсон байна. Тус сумын Засаг даргын захирамжаар 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдөр 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоожээ.

Эх сурвалж: ОБЕГ


Олон улсад:

Эбола вируст халдвар:

2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад Эбола вируст халдварын сэжигтэй тохиолдол 3250 тохиолдол бүртгэгдсэнээс 2144(67%) нь нас барсан. Нийт тохиолдлын 1827(56%) нь эмэгтэйчүүд, 921(28%) нь 18-аас доош насны хүүхдүүд эзэлж байна.



Зураг 1. Эпидемиологийн 7 хоногоор



Эх сурвалж: ДЭМБ

Хонины цэцэг өвчин:

ОХУ-ын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Тверь мужид хонины цэцэг өвчний улмаас 41 хонь өвчилсөн байна. Дээрхи тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.



Мал, амьтны галзуу өвчин:


Малайз улсын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Сарабак мужийн Кучинг хотын мал, амьтны галзуу өвчин бүртгэгдэж 1 нохойг устгасан байна. Дээрхи тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

Баруун нилийн халуурал өвчин:


Герман улсын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Саксон Анхальтын адууны фермд Баруун нилийн халуурал өвчнөөр 1 адуу өвчилж үхсэн байна. Дээрхи тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.




Эх сурвалж: ДМАЭМБ

Ласса чичрэг өвчин:

Нигери улсын Өвчний Хяналт Сэргийлэлтийн Төвийн 42 дугаар долоо хоногийн эргэн мэдээллээр Ласса чичрэг өвчний сэжигтэй 13 тохиолдол бүртгэгдсэнээс 2(15.3%) нь нас барсан байна.



Зураг 2. Эпидемиологийн 7 хоногоор



Зураг 3. Нас, хүйсээр

2019 оны 01 дүгээр сарын 01-ээс 10 дугаар сарын 20-ны хүртлэх хугацаанд Нигери улсын 23 мужаас Ласса чичрэг өвчний 4209 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнээс 739 тохиолдол батлагдаж, 156(21.1%) нь нас барсан байна.

Эх сурвалж: Promed

Африкийн гахайн мялзан өвчин:

Эх сурвалж	Хаана	Мэдээлсэн хугацаа	Өртсөн хугацаа	Нэгж	Өвчилж үхсэн	Устгасан
ДМАЭМБ	• Болгар улс • Пест тосгон	2019.10.29	2019.10.17	Ойд	2 гахай	
ДМАЭМБ	• Өмнөд Солонгос • Gyeonggi-Do	2019.10.29	2019.10.27	Ойд	1 гахай	
ДМАЭМБ	• Румын улс • Тулсиа	2019.10.30	2019.10.28	Цэцэрлэгт хүрээлэн		1 зэрлэг гахай
ДМАЭМБ	• Филиппин улс • Second дүүрэг	2019.10.30	2019.10.18			154 гахай

Эх сурвалж: ДМАЭМБ